



**НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ ДУНД
ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ
ТӨВИЙН ТҮҮХ**

Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ТӨВИЙН ТҮҮХ

Монгол улсын Засгийн газраас жижиг дунд үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх бодлогын хүрээнд 3 аймаг, 2 дүүрэгт “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв”-үүдийг байгуулж, хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд Засгийн газрын 2005 оны 64 дүгээр тогтоолоор “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”, 2007 онд “Жижиг дунд үйлдвэрийн тухай” хууль, “Тусгай сангийн тухай” хуулиудыг тус тус баталсан байна.

Тус төв нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 185 дугаар тогтоолоор Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв “НӨУҮГ” нэртэйгээр байгуулагдсан.

Нийслэлийн Засаг даргын 2009 оны 12 дугаар сарын 29-ны өдрийн 699 дүгээр захирамжаар Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв “НӨУҮГ”-ын дүрэм, бүтэц орон тоо батлагдсан бөгөөд тус дүрэмд төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг “Нийслэл дүүргүүд дэх жижиг дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид зөвлөгөө өгөх сургалт явуулах, мэдээллийн болон инкубацийн үйлчилгээ үзүүлэх” гэж тодорхойлсон билээ.

Манай байгууллага нь Монгол улсын Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2011 оны зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Нийслэлийг үйлдвэржүүлэх дэд хөтөлбөр, ХХААХҮЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газрын Хөтөлбөрүүдийг хэрэгжилтийг ханган ажиллаж байна.


Жижиг дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх, үндэсний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байрыг шинээр бий болгох, нэмэгдүүлэх зорилтын хүрээнд жижиг дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжиж, эдийн засагт жижиг дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх замаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахад манай эрхэм зорилго оршино.

Манай төвийн зорилго нь жижиг дунд үйлдвэр эрхлэгч иргэн аж ахуйн нэгжид бизнесийн сургалт явуулах, зөвлөгөө өгөх, мэдээллийн нэг цэгийн үйлчилгээгээр үйлчлэх зэргээр төрийн үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулах, шинээр бизнес эрхлэгчдийг тодорхой

хугацаанд төвд бойжуулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх замаар зах зээлд гарахад туслах явдал юм.


Тус төв анх байгуулагдахад төвийн даргаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгч Д.Баярсайхан, Ерөнхий менежерээр Ж.Янжмаа, сургалт хариуцсан мэргэжилтэнгээр О.Онон, дүүрэг хариуцсан мэргэжилтэнгээр М.Цэдэв, М.Энхзаяа, жолоочоор О.Нямдорж нарын нийт 6 ажилтан, албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр 2010 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн билээ. Өнөөдрийн байдлаар төвийн дарга, Ерөнхий менежер, сургалт хариуцсан мэргэжилтэн 2, дүүрэг хариуцсан мэргэжилтэн 3, нярав, бичиг хэргийн ажилтан, жолооч гэсэн албан тушаалд нийт 9 ажилтан албан хаагчид ажиллаж байна.

Нийслэлийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн удирдлага зохион байгуулалтын бүтэц




Боловсролын түвшингээр нь авч үзвэл 90 хувь нь дээд боловсролтой харин үлдсэн 10 хувь нь бүрэн дунд боловсролтой байна. Нийт ажилтан, албан хаагчдийг насны болон хүйсийн байдлаар нь авч үзэхэд дараах байдалтай байна.

Хүйсийн байдал




Насны байдал



Энэ хугацаанд хувийн хэвшлийн байгууллага болон Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газар, Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтэс зэрэг төрийн байгууллагуудтай хамтран Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийг сурталчлах, тэдэнд зөвөлгөө өгөх, хамтран ажиллах чиглэлээр сургалт зохион байгууллаа.





Тус төв нь Нийслэлийн 6 дүүргүүдээс жижиг дунд үйлдвэр эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн судалгааг авч сургалтанд хамрагдах боломжтой жижиг дунд бизнес эрхлэгчдээс сонгон авч төвд бойжуулан, бие даан бизнес эрхлэх чадвар мэдлэгийг эзэмшүүлэх, хямралд өртөхөөс сэргийлэх, ажлын байраа хадгалахад дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Тус төвд Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-уул дүүргийн нийт 184 орчим бичил бизнес эрхлэгчид бойжиж байгаа бөгөөд тэдгээрийг шат дараалсан сургалтанд хамруулах, зөвөлгөө өгөх, үйл ажиллагааг нь санхүүгийн талаар дэмжих чиглэлээр шат дараалсан ажлуудыг зохион байгуулж байна.



БНХАУ-ын Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх олон улсын хамтын ажиллагааны холбооны урилгаар ажлын айлчлал хийж тус холбооны нарийн бичгийн дарга Хуан Денг Вэнь тэргүүтэй албаны хүмүүстэй ажил хэргийн уулзалт зохион байгуулан цаашид хамтран ажиллахаар боллоо.



Тус төвд бойжигч ноос, ноолууран эдлэл болон сүлжмэл эдлэлийн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 30 бизнес эрхлэгч иргэдийг мэргэшлийн ур чадвар эзэмшүүлэх, шинэ техник технологитой танилцуулах, туршлага солилцох зорилгоор Монгол улсад ноос, ноолуурын чиглэлээр тэргүүлэх компаниудын нэг “Алтай Кашмир” ХХК-ний үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах ажлыг зохион байгууллаа.



“Түгээлэн ундарга” төрийн бус байгууллагатай хамтран Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд 2011 оны 12 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд Эко-Монгол үйлдвэрлэгч үзэсгэлэн худалдааг зохион амжилттай байгууллаа.



Нийслэлийн бичил бизнесийн хөгжлийг дэмжих зээлд хамруулахаар тус төвд бойжиж буй 65 өрхийн үйлдвэрлэл эрхлэдэг иргэдийн 221.8 сая төгрөгийн төслийг материалыг хүлээн авч зээлийн хурлаар хэлэлцүүлсэн болно. Эдгээр бойжигчдоос 28 бизнес эрхлэгч 76.8 сая төгрөгийн зээл авч 37 бойжигчийн материал тодорхой шалтгааны улмаас буцсан бөгөөд зээл олголт 43.1 хувьтай байна.

НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ТӨВ



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2009 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 185

Улаанбаатар х

"Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв"
Нийслэлийн өмчит газар байгуулах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн "ж" заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 77 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2009 оны 1/2710 тоот албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв" Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулсугай.

Хоёр. Шинээр байгуулагдсан нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, бүтэц орон тоо, дүрмийг баталж, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Г.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Т.БИЛЭГТ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2009 оны 12 сарын 29 өдөр

Дугаар 699

Улаанбаатар хот

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих
төв байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн "в" заалт, 29.2, 30.1.11 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв" Нийслэлийн өмчит газар байгуулах тухай 185 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв" Нийслэлийн өмчит улсын үйлдвэрийн газар /НӨУҮГ/-ын дүрмийг нэгдүгээр хавсралтаар, бүтэц орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв" /НӨУҮГ/-ын даргаар Дагвын Баярсайханыг 2010 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн томилж, үндсэн цалинг 325242 төгрөгөөр тогтоосугай.


Гурав. Нийслэлийн хэмжээнд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр, дүрмээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж, батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг батлан мөрдөж ажиллахыг "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв" /НӨУҮГ/ /Д.Баярсайхан / -т үүрэг болгосугай.

Дөрөв. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2009 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийн дагуу "Жижиг дунд үйлдвэрлэлийн төв" /НӨУҮГ/-ын ажлын байрыг "Улаанбаатар-Бизнес хөгжлийн төв"-ийн байранд шийдвэрлэхийг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /М.Однасан/, "Улаанбаатар-Бизнес хөгжлийн төв" /НӨУҮГ/ /М.Ганбаатар/-д даалгасугай.

Тав." Жижиг дунд үйлдвэрлэлийн төв" /НӨҮҮГ/-ын хэвийн үйл ажиллагааг нь хангахад шаардагдах албан ажлын автомашиныг зохих журмын дагуу ашиглуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ч.Однасан/, Төр захиргааны автобааз /Ц.Батхуягт/-т тус тус даалгасугай.

Зургаа. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын орлогч Д.Ганболдод үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Г.МӨНХБАЯР